



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№214 /423/

2022.11.29

Тусгай дугаар



СУРГАЛТ, БЭЛТГЭЛИЙН ГАЗАР ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНЫ 100 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ДЭВШҮҮЛБЭ

МЭНДЧИЛТЭЭ



Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хөгжил дэвшилд бодит хувь нэмрээ оруулан залуу нас, хөдөлмөр зүтгэлээ зориулсан үе үеийн ахмад дайчдаа болон эрхэм генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагч Та бүхэнд Цэргийн сургалтын алба үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлье!

Монголчууд бид төрт улс, төрт ёсыг үүсгэн байгуулсан цагаас эхлэн эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлынхаа төлөө баатарлагаар тэмцэж ирсэн цэрэг, арми, Зэвсэгт хүчний баялаг түүх, дайчин замналтай ард түмэн билээ. Иймээс олон зууны баатарлаг түүхтэй монгол эх орны тусгаар тогтнол, халдашгүй дархан байдлын найдвартай баталгаа нь, эрх чөлөөт ард түмний энх амгалан оршихуйн бэлгэдэл нь цэрэг эрс байсаар ирсэн юм.

Түүх сөхөх аваас, 1922 онд Бүх цэргийн зөвлөлөөс Хязгаарын ба нутгийн цэргийн бүх ангиуд цэргийн хэрэгт хэрхэн суралцаж байгаа байдлыг шалган байцааж, заавар зөвлөгөө өгч байх асуудлыг хариуцсан байцаах түшмэлд "... Бэйс Х.Чойбалсанг тоймон, харьяат түшмэлийн дагаж шийтгэх дүрэм зүйлийг тогтоон баталж, Улиастай, Ховд, Алтанбулагийн сайдууд, олон хязгаарын сайд, түшмэл, Халх, Дөрвөд 6 аймгийн жанжин, чуулганы дарга, Нийслэл хүрээний Эрдэнэ Шанзав, Хатгал харуулын төлөөний түшмэл бэйс Цэмбэлжигид, 1 дүгээр морьт бригадын ерөнхий түшмэл, их буу, даргын сургуулийн захирал нарт тус бүр явуулан тушаагаад, нэгэн адил шийтгүүлсүгэй" хэмээснээр өнөөгийн Зэвсэгт хүчний Жанжин штабын Сургалт бэлтгэлийн газрын үндэс суурь тавигдсан юм.

Өнгөрсөн XX зууны эхэнд "орших, эс орших"-ын заагт байсан манай орны түүхэнд цоо шинэ эргэлтийг авчирсан Ардын журамт цэргийн анхны ялалтаас түүчээлэн алдар гавьяа, амжилт бүтээлийн түүхээр мөнхөрсөн орчин цагийн Зэвсэгт хүчний хөгжил, шинэчлэлийн бүхий л үе шатанд Цэргийн сургалтын нэгж, албан тушаалтнуудын гүйцэтгэсэн үүрэг, оруулсан хувь нэмэр асар их билээ. Тодруулбал, энэхүү нэгэн зууны түүхэн он жилүүдэд Цэргийн сургалт бэлтгэлийн газар, хэлтэс, албан тушаалтнууд нь Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргүүдийг амжилттай хэрэгжүүлэх үйл хэрэгт иргэд, цэргийн алба хаагчдыг сурган боловсруулах, хүн амыг бичиг үсэгт сургах, цэргийн сургалт бэлтгэлийн зохион байгуулалт, агуулга, арга, хэлбэрийг боловсронгуй болгох, боловсрол, шинжлэх ухаан, соёл, урлаг, спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, улс орны бүтээн байгуулалтад оролцох, хилийн чанадад энхийг сахиулах зэрэг бүтээлч үйл ажиллагаанд ямагт манлайлагч хүчин нь байсаар ирснийг баярын энэ өдөр онцлон тэмдэглэе.

Өдгөө мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бүрдүүлэн, цэргийн сургалт бэлтгэл нь шинжлэх ухаан, технологи, инновацад суурилж, бэлэн байдал, зэвсэглэл, цэргийн техник, үүрэг гүйцэтгэх чадвараар дэлхийн жишигт хүрэхийг зорьж буй өндөр хариуцлагатай цаг үед Зэвсэгт хүчний Жанжин штабын бүтцэд Сургалт бэлтгэлийн газрыг байгуулснаар сургалт, соёл хүмүүжил, сэтгэл зүйн ажлын нэгдлийг хангах, сургалтыг тасралтгүй, чанартай явуулах удирдлага, зохион байгуулалт, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх боломж бүрдлээ.

Цаашид Зэвсэгт хүчний өмнө дэвшүүлсэн бодлого, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэх, цэргийн сургалтад дэвшилтэт арга, технологи, инновацыг нэвтрүүлэх, нийт бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх, мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын үр дүнг нэмэгдүүлэх, олон улсын сургууль, сургалт, дадлагыг өндөр үр дүнтэй, хүртээмжтэй зохион байгуулах ажилд манлайлах үүргийг хүлээж, өмнөх ололт, амжилтаа улам бататгаж, бүтээлч, шинэлэг үйл ажиллагаагаар бахархам түүх, дайчин уламжлалаа улам бүр баяжуулна гэдэгт итгэл төгс байна.

Та бүхэндээ Цэргийн сургалт бэлтгэлийн алба үүсэж хөгжсөний түүхт ойн баярын мэндийг дахин дэвшүүлж, ажлын арвин их амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Монгол цэргийн бахдам түүх, бахархам амжилт үеийн үед мандан бадрах болтугай!

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА
БРИГАДЫН ГЕНЕРАЛ С.ГАНБЯМБА**

Өнөөдөр Цэргийн сургалт бэлтгэлийн 100 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн ажиллагаа ёслол төгөлдөр боллоо.

Эл хуралд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал

хамгаалахын эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд төрөөс батлан хамгаалах талаар баримтлах бодлогыг дэлхийн цэрэг-улс төрийн нөхцөл байдал, гадаад орнуудын батлан хамгаалах бодлого, өөрчлөлттэй уялдуулан шинэчилж,



С.Ганбямба, Сургалт бэлтгэлийн газрын дарга, бригадын генерал Г.Болор, Чөлөөнд байгаа дэслэгч генерал Ж.Моломжамц болон БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалуудын удирдлага, цэргийн биеийн тамир, спортын үе үеийн генерал, офицер, ахлагч, ажилтан, алба хаагчид тус газрын тулганы чулууг тулж шинэчлэлийн замд хөтөлсөн ахмад дайчдын төлөөлөл оролцлоо.

Баярын хурлыг нээж бригадын

холбогдох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох зорилтыг үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж буйг онцлоод Төрийн бодлого, хууль тогтоомжоор хүлээсэн Зэвсэгт хүчний чиг үүрэг, төр засгаас дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, сургалтын тогтолцоогоо өөрчилж, шинэ шатанд гаргах, цэргийн сургалтыг бүх шатанд тасралтгүй төлөвлөн явуулах, удирдлагаар хангаж, мэргэжлийн цэргийг бүрдүүлэхэд шаардлагатай



генерал Г.Болор хэлсэн үгэндээ ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газар нь Зэвсэгт хүчний цэргийн сургалт, бэлтгэл, сэтгэлзүйн хангалтын бодлогыг тодорхойлох, сургалтын тогтолцоог боловсронгуй болгох орон нутгийн цэрэг, томилгоот нэгжүүд болон бүх нийтийг цэргийн хэрэгт сургаж бэлтгэх, алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хангах, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, хүүхэд, залууст цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж буйг онцлоод цаашид төрөл мэргэжлийн цэргийн онцлолт тохирсон сургалтын бие даасан тогтолцоог бүрдүүлэх, дэлхийн тэргүүлэгч улс, орнуудын Зэвсэгт хүчинд нэвтэрсэн манлайллын номлолыг өөрийн улс орны хөрсөн дээр буулгаж, ажил хэрэг болгох цэргийн сургалт, бэлтгэлийн харилцан хамаарлыг хангахад онцгой анхаарч ажиллахаа илэрхийлсэн юм.

Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр үг хэлсэн юм. Тэрээр Батлан хамгаалахын эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох зорилтыг үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж буйг онцлоод Төрийн бодлого, хууль тогтоомжоор хүлээсэн Зэвсэгт хүчний чиг үүрэг, төр засгаас дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, сургалтын тогтолцоогоо өөрчилж, шинэ шатанд гаргах, цэргийн сургалтыг бүх шатанд тасралтгүй төлөвлөн явуулах, удирдлагаар хангаж, мэргэжлийн цэргийг бүрдүүлэхэд шаардлагатай чадварлаг хүний нөөцийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэхэд цэргийн сургалт бэлтгэлийн газрын хамт олон Та бүхний идэвх санаачилга, оролцоо хамгаас чухал хэмээлээ.

Мөн энэ үеэр эрхэлсэн ажилдаа он удаан жил үр бүтээлтэй ажиллаж амжилт гаргасан ажилтан, алба хаагчдыг Батлан хамгаалах салбарын болон төрийн одон медалиар шагнаж урамшууллаа. Тухайлбал Цэргийн гавьяаны одонгоор ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн захирагч хурандаа Ш.Гантулга, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга хурандаа Д.Цог-Эрдэнэ, Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор бэлтгэл хурандаа Ё.Цэрэндаваа тэргүүтэй хүмүүсийг тус тус шагналаа. Хурлын төгсгөлд ЦДБЭЧ-ын уран бүтээлчид тус газрын 100 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн тоглолтоо хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчид үзэгч олонд өргөн барьсан юм.





ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН СУРГАЛТ, БЭЛТГЭЛ ЯМАР ХЭМЖЭЭНД БАЙГААГ ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ХАРУУЛЖ БАЙНА

Чөлөөнд байгаа дэд хурандаа С.ЛУВСАННАМЖИЛ:
-Би 1962 оны цэрэг, 1964-1982 оны хооронд Монголын Ардын Армийн химийн анги, салбаруудад алба хаасан. Тодруулбал, 1968 онд одоогийн 119 дүгээр ангийг анх байгуулагдахад ротын дарга, 1979 онд 198 дугаар ангийн захирагч, 029 дүгээр ангийн Офицеруудын мэргэжил дээшлүүлэх курсийн багш зэрэг албан тушаалыг хашиж байгаад 1982-1990 онд тухайн үеийн БХЯ-ны Байлдааны



бэлтгэлийн газар буюу 13 дугаар газарт барилгын цэрэг, Армийн улирагчдыг хариуцсан офицероор алба хаагаад гавьяаныхаа амралтад гарсан. Тухайн үед манай газрын даргаар дэслэгч генерал Ш.Жадамба, Ш.Арвай, хошууч генерал Ц.Галсан гээд мундаг хүмүүс ажиллаж байлаа. Миний хувьд энэ хүмүүсийн удирдлагад их ч зүйлд суралцаж, их ч ажил нугалсан байдаг юм. Түүнээс онцлон дурдвал, дайчилгаагаар яаж дивизийг зохион байгуулдгийг, цаашлаад яаж армийг бүрдүүлдгийг манай хамт олон гардан зохион байгуулсан. Түүнчлэн 1984 онд манайд далд байгаа хүчийг устгах зориулалт бүхий байлдааны нисдэг тэрэг анх нэвтэрч бид өдгөөгийн Таван толгой дахь Сургалтын төвд ББТХС-ийг зохион байгуулж байсан зэрэг содон үйл явдлууд бишгүй бийг дурдахад таатай байна.

Өдгөө цаг үе, олон улсын нөхцөл байдал өөрчлөгдөж байна. Манай Зэвсэгт хүчний хувьд ч дэлхийн жишигтэй хөл нийлүүлж, Монгол цэргийн нэр хүнд дэлхий дахинаа цуурайтаж байгаад өвгөн би ихэд баярлаж суудаг. Манай монгол цэргүүд энхийг сахиулах ажиллагаанд манлайлан оролцож, үүрэг гүйцэтгэх ур чадвар, сахилга бат, тэсвэр хатуужлаараа дэлхийд гайхагдаж байна шүү дээ. Энэ бол цэргийн алба хаагчдын сургалт, бэлтгэл ямар хэмжээнд байгаагийн нэг илрэл юм. Үндсэндээ сургалт, бэлтгэлийг хэрхэн чанартай зохион байгуулах вэ гэдгийг төлөвлөхөөс нь эхлээд хэрэгжүүлэх хүртэл ажил хэрэг болгож байгаа шат шатны хүмүүсийн гавьяа гэж хардаг юм. Энэхүү гавьяагаа өнөөдөр нэгэн зуунаар баринтаглаж байна, цаашид ч энэ үйл хэрэг тасрахгүй үргэлжилнэ. Ингээд олон зүйлийг эс нуршин өнөөгийн ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн газрын 100 жилийн ойн мэндийг Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд уламжилж, ажлын их амжилтыг хүсэн ерөөе.



БХЯ-ны Биеийн тамирын сургалт, эрхэлсэн офицер, бэлтгэл дэд хурандаа Д.НАЙДАН:

ТУС ГАЗАР АЖИЛЛАСАН МИНЬ ХАМГИЙН САЙХАН ДУРСАМЖ БАЙДАГ

Бэлтгэл хурандаа Б.МАГВАНСҮРЭН
-Би 1965 оны цэрэг. Манай оронд Пуужингийн дивизин буюу Ардын Армийн 028 дугаар анги анх байгуулагдахад 67 цэрэг байсны нэг нь би. 45 хоногийн карантинд хамрагдаад техникийн батареинд жагсаалын даргаар түрүүч цолтойгоор томилогдож энэ салбартай холбогдож байлаа. 1967 онд манай оронд анхны пуужингийн буудлага Зоргол хайрханд болсон юм. Би тус буудлагад оролцож цэнэглэсэн пуужинг харвах суурьт байрлуулах каранистын үүргийг гүйцэтгэсэн нь дарга, удирдлагад өндөрөө үнэлэгдэж, улмаар "хойно" ар талын чиглэлээр сургуульд явуулах болов оо. Гэтэл би гэдэг том толгойтой хүн тухайн үед шуудхан татгалзсан. Чухамдаа цэргийн албанаас халагдаад биеийн тамир, спортын чиглэлийг хөөх бодолтой байсан хэрэг л дээ. Гэтэл Т.Алтангэрэл генерал намайг дуудаж уулзаад "Чи ийм боломжийг алдах гэж байдаг яасан хачин хүүхэд вэ. Тэгвэл чамайг Киев хот руу радио техникийн инженерээр

явуулъя" гэж хэлсэн. Би ч зөвшөөрч тус хотод зургаан жил суралцаж эх орондоо ирээд өөрийн ангидаа батареины даргаар томилогдов. Тэр үед бид онц анги болох том зорилтыг тавьж ажилласны үр дүнд миний бие армийн анхны онц батареин дарга болж ахлах дэслэгч цолоор шагнуулж, Октябрийн районы депутатаар сонгогдож явсан сайхан түүх бий. Улмаар би 1976 онд БХЯ-ны Байлдааны бэлтгэлийн газарт биеийн тамир хариуцсан офицероор томилогдсоны дараа "хойно" түргэвчилсэн курст сурч ирээд сургалтын офицероор үүрэг гүйцэтгэх болов. Тухайн үед МАА-ийг эд өргөтгөн зохион байгуулж Сургуулийн дивиз байгуулагдаж цэргийн бага мэргэжилтнүүдийг бэлтгэдэг болсон. Үндсэндээ энэ ажлыг би хариуцдаг байв. Үүнийг хажуугаар "Алдар" нийгэмлэгийг хариуцаж ажиллана гэсэн үг. Би өөрөө ч спортод их дуртай хүн. Байлдааны бэлтгэл шалгах ажлаар анги, салбаруудаар явах болгондоо спортод дөртэй цэргүүдийг

САЙХАН ЧАНАРЫГ ЦОГЦЛООСОН ХҮМҮҮСТЭЙ ЦУГ АЖИЛЛАЖ БАЙЛАА

-Би 1983 онд Хуучнаар ЗХУ-ын "Хоёр удаагийн одонт Биеийн тамирын дээд сургууль"-ийг төгсөж ирээд Ардын армийн 150 дугаар ангид биеийн тамир эрхэлсэн штабын туслахаар ажиллаж байгаад 1985 оноос Байлдааны бэлтгэлийн газарт биеийн тамир, сургалт эрхэлсэн офицероор дэвшин ажиллаж байлаа. Тус газарт ажиллаж байх хугацаандаа чадварлаг хамт олны дунд хөгжин дэвшиж, олон ч зүйлд суралцсан нь цаашдын ажил, амьдралд минь ихээхэн хэрэг болсон. Тухайлбал манай хамт олны хувьд ажилдаа няхуур, хурдан, шуурхай сэтгэлээсээ хийдэг, даруу төлөв зантай, ажлыг сайн төлөвлөж, зохион байгуулдаг, хойш суудаггүй, багаар ажиллах чадвартай,

хүнд тусархуу, сайхан сэтгэлтэй гээд олон сайхан чанарыг цогцлоосон хүмүүстэй цуг ажиллаж байлаа. Иймдээ ч өдгөө улс орны томоохон бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчин идэвхийлэн оролцож, бие бүрэлдэхүүнээ төмөр зам, гүүр, барилга, байгууламжийн ажилд сургаж бэлтгэн, төр засгаас даалгасан өндөр хариуцлагатай үүргийг нэр төртэй гүйцэтгэж байгааг цэргийн сургалт бэлтгэлтэй холбон ойлгож болох юм.

Өдгөө ажил амьдралын минь салшгүй нэг хэсэг болж, олон ч сайхан түүх дурсамжийг бүтээсэн тус газрын 100 жилийн ой тохиож байна. Баялаг сайхан, бахархам их түүхт газрын хамт олондоо цаашдынх ажил, албанд эрүүл энх, саруул сайхан бүхнийг хүсье.



тус нийгэмлэгтэй холбодог байлаа. Намайг тус газарт 1980 оныг хүртэл ажиллах хугацаанд сургуулийн дивиз маань сайн дүн авч захирагч хурандаа Р.Гүнчин-Ишд генерал цол олгож байсан. Дараа нь тэрхүү генерал цолны цайллага дээр Р.Гүнчин-Иш генерал "Миний энэ цолыг Б.Магвансүрэн авч өгсөн гэхэд буруудахгүй шүү" гэж намайг магтаж байсан сайхан үг миний санаанаас ерөөс гардаггүй юм.

ЦЭРГИЙН СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА ХОЁРЫГ САЛГАЖ ОЙЛГОЖ БОЛОХГҮЙ

МУСТА бэлтгэл хурандаа З.БАЯРМАГНАЙ
-Би 2010-2012 онд Иргэн-цэргийн харилцааны хэлтэст ажиллаж байлаа. Тухайн үед ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газар Төлөвлөлт бодлогын хэлтэс, Энхийг дэмжих ажиллагааны хэлтэс, Сургалтын хэлтэс, Иргэн-цэргийн харилцааны хэлтэс гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулдаг байв.
Дэслэгч генерал Д.Ганзориг, бригадын генерал С.Дашзэвэг, Д.Баасандамба, хурандаа Д.Дугаррагчаа зэрэг олон сайхан дарга нартай итгэл, сэтгэл, зүрхээрээ гэр нийлэн ажиллаж, ЗХЖШ-ын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх үйлсийг бүтээлцэж явсан он цаг маань миний амьдралын

дурсамж дүүрэн мөчүүд юм. Ер нь цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах, үр дүнд хүргэх, бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадвар, чадамжийг дээшлүүлэхэд мэдээлэл, сурталчилгаа чухал нөлөө үзүүлдгийг хэзээ ч мартаж болохгүй. Тийм болохоор цэргийн сургалт, мэдээлэл сурталчилгаа хоёрыг салгаж ойлгож болохгүй юм. Тухайн үед бидний үйл ажиллагааг ойлгож, дэмжиж тусалж байсан БХЯ, ЗХЖШ-ын удирдлага, хамт олон, манай хэлтсийн үйл ажиллагаа бүрд дэмжлэг тусалцаа үзүүлдэг ЦДБЭЧ, "Соёмбо" редакци, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын төв архив зэрэг байгууллагадаа чин сэтгэлээсээ талархаж явдгаа энэ дашрамд хэлэхэд таатай байна. Цэргийн сургалт, бэлтгэл гэдэг бол олон хүний



хүч хөдөлмөр, цаг хугацаа, итгэл зүтгэл шингэж байж бий болж, үр дүнд хүрдэг ажил юм шүү гэдгийг энд онцлон хэлье.